



МОНГОЛЫН
ХАМГААГАХ
УЛАМГАЙН
ХАМГААГАХ
МОНГОЛ

2023-2024 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын тайлан






ШИНЭ ХӨГЖИЛ СУРГУУЛЬ

Манай сургууль
2023-2024 оны хичээлийн
жилд 60 бүлэгт
2090 сурагч, 81 багш,
38 ажилтантай сургалт
хүмүүжлийн үйл ажиллагаа
явууллаа.

Багшийн хангалт
98 %

Мэргэжлийн зэрэгтэй
багшийн эзлэх хувийг
графикаар харуулбал:



Зөвлөх, тэргүүлэх, заах аргач зэрэгтэй
багшийн эзлэх хувь 66.6%

Магистр багш 28 байгаа нь нийт багш
нарын 34.5% хувийг тус тус эзэлж байна.

1. Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах



Дотоод сүлжээний утасгүй интернетийн 14ш төхөөрөмж, цахим анги, 49ш chromebook, сурагчдад 120ш таблет



Англи хэлний цахим хөтөлбөрт 5, 6 дугаар ангийн 10 бүлгийн 386 сурагч



Математикийн 3-4 дүгээр ангийн цахим хөтөлбөрт 11 багш, 438 сурагч



10 дугаар ангийн 28 сурагч, 10 хичээл 11 дүгээр ангийн 28 сурагч, 4 хичээлээр хамрагдлаа.



- Дээрх цахим технологиуд суурилсан pearson, eduten, мэдлээ нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, цахим орчин нөхцөлийг бүрдүүлж амжилттай хэрэгжүүллээ.
- **Pearson** гүйцэтгэлийн дундаж 79,8% буюу гарааны үнэлгээнээс 6.8% ахисан, **eduten**-Оношлох үнэлгээ, эцсийн үнэлгээг харьцуулахад 3 дугаар анги 10.8%, 4 дүгээр анги 9.7%-иар ахисан үзүүлэлттэй байна. **Мэдлээ** цахим сургуулийн ирцийн хувийг нэмэгдүүлж ажиллалаа.

Ахлах ангийн сурагч технологийн дэвшил ашиглан орон зайнаас үл хамааран хичээлээ сонгон судлах тэгш боломж бүрдүүлж ажиллалаа.

Судлагдахуун -10, 56 сурагч

Дунд, ахлах ангийн сурагчид ашиглах 75ш таблет, цахим анги



Үр дүн: Цахим сургуулийн сурагчид нь орон зайнаас үл хамааран суралцаж, өөрийн авьяас, давуу тал, чадвараа хөгжүүлж, ажил мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлох, сонгон судлах давуу талтай.

2. Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах

Сургууль,
цэцэрлэгт
хөгжлийн
бэрхшээлтэй 14
сурагч

“Сэтгэл
зүйчийн цаг”
• Сурагч, багш,
ангийн
сурагчид, эцэг
эхтэй уулзалт,
зөвлөгөө

Сургалтын орчин:
• Бага сургуульд
• уншлагын танхим
• Налуу шат
• АЦ-өрөөний
тулгуур, бариул

Зорилтот бүлгийн 10
өрхийн 12 сурагчийн
ар гэрээр очиж
эрсдэлд өртөхөөс
урьдчилан
сэргийлэх зөвлөгөө,
мэдээлэл





**Ганцаарчилсан
сургалтын хөтөлбөр**

Үр дүн

03


4-р ангийн сурагч Д 1-2 үгтэй үеийг шууд уншдаг болсон. Богино эхийг цэвэр нямбай, алдаагүй хуулж чаддаг болсон.

02

5-р ангийн сурагч М 100 дотор нэмэх, хасах үйлдлийг бодож чаддаг болсон. Минутад унших үгийн тоо 23 болж ахисан бөгөөд өөрт нь зориулан бэлтгэсэн 2-3 дасгалыг 40 минутад бие даан ажиллах чадвартай болсон.

01

3-р ангийн сурагч О нь хүнд хэлбэрийн оюуны бэрхшээлтэй. Энэ хичээлийн жилд үзгээ зөв барьж, өнгө ялгах, 3 эгшиг үсгийг зөв нэрлэх, зурагт байгаа эд юмсыг тоочин нэрлэх чадвартай болсон.



ЭНЭ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД 675 СУРАГЧИЙГ СОНГОН, ДУГУЙЛАН БОЛОН СӨУБ- Д ХАМРУУЛЛАА.

Хөл бөмбөг - 32

01

Сагсан бөмбөг - 24

02

Волейбол - 46

03

Шатар даам - 37

04

Сэтгэх чадвар - 57

05

- Манай сургуульд 12 төрлийн дугуйланд 402 сурагч хамрагдлаа.
- "After school" платформоор дамжуулан ахлах ангийн 150 сурагч хичээлээс гадуурх дугуйлан секцэд хамрагдаж, мэдлэг мэдээлэлтэй болсон.
- Сургуулийн хүүхдийн өөрийн удирдлагын Өсвөрийн цагдаа, Улаан загалмай, Скаут, Сурагчдын зөвлөл, Эрүүл мэндийн клубт нийт 123 суралцагч хамрагдаж нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан.
- Эдгээр үйл ажиллагаанд хамрагдсан сурагчид өөрийн авьяас чадвараа хөгжүүлж, бусдад эерэг нөлөөлөл үзүүлж, хамтран суралцлаа.

06

Зураг, сийлбэр - 56

07

Найрал дуу - 32

08

Цахилгаан хөгжим- 6

09

Үндэсний хөгжим- 16

10

Гадаад хэл- 96



3. Байгууллагын менежментийн төлөвлөлт, цэцэрлэг, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох



ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ШИНЭ ХӨГЖИЛ СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗУРАГЛАЛ 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ



БШУЯ-ны ЗОРИЛГО

Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэг, сургуулийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах жил

АЛСЫН ХАРАА

Эерэг хандлагатай, бүтээлч сэтгэлгээтэй, зөв дадал хэвшилтэй, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлнэ.

СУРГУУЛИЙН ЗОРИЛГО

Бие даан суралцах чадвартай, хүмүүжил төлөвшил сайтай, зөв дадал хэвшилтэй хүүхдийг төлөвшүүлнэ.

СУРГУУЛИЙН ҮНЭЛГЭЭ

- Сургуулийн дундаж 77.05% Индекс IV.
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 58.96%
 - Хүүхдийн хөгжил, хамгаалал 85.4%
 - Багшийн хөгжил 89.95%
 - Сургалтын орчин 80%
 - Удирдлагын манлайлал, менежмент 76.47%
 - Сэтгэл ханамж 77.13%

АНХААРАХ АСУУДАЛ

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 58.96%

СУРАГЧИЙН ДҮР ТӨРХ

Сурах арга барил эзэмшсэн, хүмүүжил төлөвшил сайтай, зөв дадал хэвшилтэй хүүхэд

ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТУУД

Сурагч: Бие даан суралцах чадварыг нэмэгдүүлэх
Зөв дадал хэвшил төлөвшүүлэх
Багш: Ээлжит хичээлийн бэлтгэлийг бүрэн хангах
Суралцахуйн зорилтын үйл бүрийг ээлжит хичээлд төлөвлөх
Бүтээлч аргуудыг сургалтад ашиглах

БАГШИЙН ДҮР ТӨРХ

Ээлжит хичээл бүрийг өгөөжтэй заадаг, суралцахуйн зорилтоо бүрэн шинжилж, сургалтын бүтээлч аргуудыг туршин хэрэгжүүлдэг.

ЧИГЛЭЛ

Багшийн хөгжил

Сурагч бүрийн ахиц

Эрүүл дадал хэвшил

Сургуулийн соёл

Хүүхэд хөгжил, хамгаалал

Эцэг эх, оролцоог нэмэгдүүлэх

ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Захиалгат сургалт
- МХБ-ийн хамтын ажиллагаа
- Залуу багш нарыг дагалдуулан сургах хөтөлбөр

- Ойлгон унших чадвар
- Сэтгэн бодох, шинжлэн судлах арга барил
- Гадаад хэлний унших, бичих чадварыг хөгжүүлэх
- Ур авьяасыг хөгжүүлэх

- Цахим орчин дахь зохистой хэрэглээ
- Улирлын онцлогт тохируулан хувцаслах
- Сэтгэл хөдлөлөө эерэгээр удирдах чадварт суралцах

- Мэндлэх, талархах
- Эерэг хандлага
- Цаг баримтлах
- Дүрэмт хувцас иж бүрэн, цэвэр өмсөх
- Хог хаяхгүй хэвшилд сурах

- Хөгжлийг дэмжсэн дугуйлан, секцэд хамруулах
- Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжсэн сургалтууд

-Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх
-Хүүхдийн бие даан суралцах арга барилыг дэмжсэн ажилд улирал тутам оролцох

ШАЛГУУР

Бүтээлч аргуудыг сургалтад ашиглаж, үр дүнд хүрсэн байдлаар

Бие даан, бүтээлчээр суралцах чадвар эзэмшсэн байдлаар

Зөв дадал хэвшил, боловсон харилцаагаар

Сургуулийн соёл, дэгийг мөрдөж, хэвшил болсон байдлаар

Хүүхдэд ээлтэй сурах, хөгжих орчин бүрдүүлсэн байдлаар

Эцэг эхийн оролцоо, сэтгэл ханамжийн судалгаагаар

ҮР ДҮН

Зөв дадал хэвшилтэй, сурах хүсэл эрмэлзэлтэй, эерэг хандлагатай сурагч.

Ээлжит хичээл бүрийг өгөөжтэй заадаг, суралцахуйн зорилтоо бүрэн шинжилж, сургалтын бүтээлч аргуудыг туршин хэрэгжүүлдэг багш

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ээлжит хичээлийн чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

Интеграц хичээл

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, чанар үр өгөөжийг дээшлүүлэх, хичээл хоорондын залгамж холбоог хангах ажлын хүрээнд “Интеграц хичээл” үйл ажиллагааг зохион байгууллаа. Үйл ажиллагаанд 52 багш сонирхолтой хослол үүсгэн, 26 хичээл заасан бөгөөд давхардсан тоогоор 126 багш хэлэлцүүлэгт оролцож арга зүй туршлагаа түгээн дэлгэрүүлсэн. Энэхүү хичээл үйл ажиллагаа нь багш, сурагчдын хичээлийн идэвх оролцоог нэмэгдүүлсэн, талархлыг хүлээсэн ажил боллоо.

Дэвтэр сурагчийн толь

Сурагчдын хичээлийн идэвхийг нэмэгдүүлэх, сурлагын хоцрогдлыг бууруулах ажлын хүрээнд “Дэвтэр сурагчийн толь” сарын аяныг дунд ахлах ангийн сурагчдын дунд өрнүүллээ. Аянд дунд, ахлах ангийн 936 сурагч 100 хувь хамрагдаж судлагдахуун тус бүрийн хичээлийг бүтээлчээр тэмэглэж дэвтрийг үйл ажиллагааг жигдрүүллээ. Мөн сурагчдын дэвтрээр үзэсгэлэн гаргаж, видео хэлбэрээр сурагчдад танилцууллаа.


Самбар хичээлийн толь

Багш бүр ээлжит хичээлийн төлөвлөлтийг самбар төлөвлөлтийн хамт батлуулж хичээлээ зохион байгуулж ажиллалаа. Нэгдлийн ахлагч нар багш нарын самбар төлөвлөлтийн зургийг нэгтгэн танхимаар болон сургуулийн албаны бүлэг, цахим орчинд мэдээлж арга зүй туршлагыг танилцуулсан. Үүний үр дүнд багш нарын хичээлийн бэлтгэл, самбар төлөвлөлт сайжирч сурагчдын хичээлийн идэвх оролцоо нэмэгдсэн.



5 кабинет тохижууллаа.

Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан сурах, бие даан, бүтээлчээр хөгжих, төлөвших үйлийг дэмжих, сургалт үйл ажиллагааг зохион байгуулах Үндэсний бичиг, математик, биологи, эмэгтэй технологи, физикийн кабинетийг тохижуулан хичээл сургалтын таатай орчин бүрдүүлэн ашиглаж байна.



Сургалтын орчныг сайжруулах чиглэлээр: /Гадаад орчин/

2023 оны 10 сард сургуулийн дулааны шугам хагарч хүндрэл үүссэн. Хагарсан 60м шугамыг багш ажилчдын оролцоотой засварлаж халаалтыг хэвийн дамжуулсан.

Байгууллагын эзэмшлийн талбайд шинээр бэсрэг 5 алим, 4 торниун алим тарьсан. Мөн 108 улиас, 38 нарс, 175 голт бор, 54 шар хуас, 114 чацаргана, 21 үхрийн нүд зэргийг хэлбэржүүлэн тайрч, цэнэг усалгаа хийсэн. Улиасыг хорхой шавжаас хамгаалах, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор модны ёроолоос дээш 1 метр орчим шохойдсон.



Сургалтын орчныг сайжруулах чиглэлээр: /Дотоод орчин/

- 2023 оны хичээлийн жилд Хэрлэн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 980.0 сая төгрөгийн их завсарт орж сургалтын таатай орчин бүрдлээ.

- Сурагчдын 1-р улирлын амралтаар бага сургуулийн заалны 32 сандал, ханын тохижилтыг ажилчдын оролцоотой шинээр хийсэн.
- Цэцэрлэгийн ажилчдын хувцасны шүүгээ
- Ахлах сургуулийн үүдний хэсгийн тохижилт, 7ш сандал





СУРАЛЦАХУЙД СУУРИЛСАН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙН БҮЛЭГ

Унших, бичих чадварыг хөгжүүлэх бүлэг
1-3 дугаар ангийн 17 багш

Унших, найруулан бичих чадварыг хөгжүүлэх бүлэг
4-5 ангийн 11 багш

Найруулан бичих, илтгэх чадварыг хөгжүүлэх бүлэг
МХ, НУ-ны 14 багш

Сэтгэн бодох, шинжлэн судлах чадварыг хөгжүүлэх бүлэг
Байгалийн ухааны 13 багш

Гадаад хэлний мэдлэгийг хөгжүүлэх бүлэг
Орос, англи хэлний 11 багш

Ур авьяасыг хөгжүүлэх бүлэг
Хөгжим, БТ, Технологи 15 багш

- 1-3-р ангийн сурагчдын ойлгон унших чадварыг хөгжүүлэх

- 4-5-р ангийн сурагчдын ойлгон унших, зохион найруулах чадварыг хөгжүүлэх

- Дунд, ахлах ангийн сурагчдын найруулан бичих, ярих, илтгэх чадварыг хөгжүүлэх

- Сурагчдын сэтгэн бодох, шинжлэн судлах чадварыг хөгжүүлэх

- Сурагчдын орос, англи хэлний үгийн санг нэмэгдүүлэх, үгийн дуудлагыг сайжруулах

- Сурагчдын урлаг, спортын авьяасыг нээн хөгжүүлэх

- Эцэг эхийн дэмжлэгтэй уншлага
- Номтой өглөө
- Оройн уншлага
- Хичээнгүй бичиг

- Номтой өглөө
- Оройн уншлага
- Найруулан бичих
- Шүлэг, эх дуурайн зохиох

- "Миний ертөнц" /6-9 анги/
- Зохиолын хэлэлцүүлэг
- Үгийн бэрс мэтгэлцээний клуб
- "1 багш -1 анги" /Үндэсний бичиг/

- Бяцхан туршилтууд
- 1000 бодлого
- Хүрд цээжлэх аян
- Газрын зурагтай ажиллах

- Найрал дууны тэмцээн /Орос хэл 8-9 анги/
- 7 хоногт 20 үг цээжлэх аян
- Team teaching үйл ажиллагаа
- Spelling бее-үгийн сан
- Speaking club-ярих

- Үндэсний хөгжим
- Сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг
- Сийлбэр, зургийн дугуйлан

МХУЗ-ын багш С.Үүрийнтуяа ахлагчтай МХ, НУ-ны багш нарын чиглүүлэн ажилласан “Сурагчдын найруулан бичих, илтгэх чадварыг хөгжүүлэх” Мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааны үр дүнгээс

**“Үгэн бэрс”
мэтгэлцээ -
ний клуб**

Клуб нь 23 сурагчтай,
7 хоногт 2 удаа хичээллэдэг.
“Карл поппер”-ын мэтгэлцээнд
1-р байр, “Дорнодын ирээдүй”
уран илтгэлд 2-р байр



**Зохиолын
хэлэлцүүлэг**

6-11 дүгээр ангийн 25 бүлгийн
875 сурагч анги нийтийн
хэлэлцүүлэгт, бүлгүүдийн дундах
хэлэлцүүлэгт 175 сурагч
оролцсон.



**“Миний
ертөнц”
дэвтэр**

8-9 дүгээр ангийн 10 бүлгийн
328 сурагч тус бүр хамгийн бага
даа 10-15 зохиолын тэмдэглэл
хөтөлсөн.



**Хэлц үгийн
тайлбар**

7-8 дугаар ангийн 10
бүлгийн 384 сурагч 100
хэлцийн утгыг тайлбарлаж
хэрэглээ болгосон.



4. “Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх

Зөвлөх багш-2,
Тэргүүлэх зэрэгтэй
25 багш

1-5 жил ажиллаж
байгаа 24 багш

Тэргүүлэх зэрэгтэй
багш
Үзүүлэх 24 хичээл

Залуу багш
Урилгат 48 хичээл

Энэ хичээлийн жилд манай сургуульд 1-5 жил ажиллаж байгаа 24 ажиллалаа. Эдгээр залуу багш нарыг Тэргүүлэх зэрэгтэй 25 багшид дагалдуулан сургах ажлын хүрээнд ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, анги удирдах, арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр хамтран ажиллалаа.

Үр дүн: Багш нарын хамтын ажиллагаа сайжирч, ажлын байран дээрээ тасралтгүй хөгжиж, туршлага арга зүйгээ харилцан солилцож, сайн хичээлийн сангаа 72 хичээлээр баяжууллаа.



Туршлага түгээн дэлгэрүүлэх чиглэлээр...



Англи хэлний багш Д.Цэцэгжаргал нарын хамтарсан баг Азийн Англи хэлний багш нарын их хуралд "Зүрх сэтгэлийн боловсрол" сэдвээр илтгэл хэлэлцүүлэхээр аймагт шалгаран бэлтгэл ажилдаа ороод байна.

Зүүн бүсийн "Жаахан шаргын нутаг-2024" шилдэг арга зүй, туршлага түгээн дэлгэрүүлэх уралдаанд МХ-ний судлагдахууны баг "Унш унш бас дахин унш" цахим бүлгэмээр дамжуулан уран зохиолын хичээлээр сурагчдыг хөгжүүлж буй арга туршлагыг танилцуулж түгээн дэлгэрүүлсэн.

Сургалтын менежерүүдийн МХБ-ийн үйл ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 20-нд зохион байгуулж өөрийн сургуулийн менежментийн сайн туршлага, ээлжит хичээлийн хэлэлцүүлэг, техник технологийн давуу талыг хэрхэн үр дүнтэй ашиглаж байгаа зэрэг үйл ажиллагаагаа түгээн дэлгэрүүлсэн. Үйл ажиллагаанд 18 сургалтын менежер танхимаар, 16 сургалтын менежер онлайнгаар оролцлоо.

Энэ хичээлийн жилд туршин хэрэгжүүлж үр дүнд хүрсэн арга зүй, туршлагыг түгээн дэлгэрүүлэх "ONE PAGE" үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд бага, дунд ангийн 48 багш оролцож шилдэг арга зүй, туршлагаа сургуулийнхаа багш нарт түгээн дэлгэрүүллээ.

Англи хэлний багш С.Мөнгөнтулга ЕБС-уудын Англи хэлний багш нар зориулсан Үндэсний хэмжээний "Enrichment Program ELT- 2024" хөтөлбөрт оролцон туршлага арга зүйгээ танилцуулж Шилдэг 10 багшийн 1-ээр шалгарсан.



5. Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

Цэцэрлэгийн багш

- Миний мэдэх тэр

Ажилтан, албан хаагчид

- Та ямар хэв шинжийн стресстэй вэ?

Бага ангийн багш

- Аз жаргалын мод

Дунд, ахлах ангийн багш

- Зургаан минутын зураг

Хамт олонд

- Зүрх сэтгэлийн дэлгүүр

5 удаагийн сургалт, сургалтын ирц-96%

Овог нэр: Баваасангийн Орлид
Мэргэжил: Сэтгэл судлах, сэтгэл судлалын багш
Мэргэшил: Боловсролын сэтгэл зүйн
Төгссөн сургууль: Монгол Улсын Их Сургууль
Хүмүүжилгүйн Ухааны Их Сургууль
Боловсролын зэрэг: Боловсрол судлалын магистр
Ажлын туршлага: Хүүхдийг Ивэх сан /Ангил/ Дорнод салбар
МУИС Дорнод аймаг дахь сургууль
Холбоо барих: 89305280
b.origi0528@gmail.com
Ихний байр: Баян суурium, №2017



Үр дүн: Хамт олны таатай уур амьсгал бүрдүүлэхэд эерэгээр нөлөөлж, тэдний ажлын эрч хүч, бүтээлч сэтгэлгээ, санаачилгатай ажиллахад дэмжлэг түлхэц болж, улмаар сурагчдын хөгжил төлөвшилд ахиц гарч байна.

**ХАМТ
ОЛОН**

**ЭВ
НЭГДЭЛ**

УРЛАГ

СПОРТ

АМРАЛТ

АЯЛАЛ



Аялал, амралт, сургалт, туршлага судлах ажлаар...

ЭЕШ-д өндөр
оноотой үнэлэгдсэн
3 багшийг Хятад
улсын 4 хотоор
аялуулсан.

Эмэгтэйчүүдийн
зөвлөлөөс
байгууллагын эрэгтэй
17 багш, ажилчдыг
Манжуур, Хайлаар
хотын аялал

Сүхбаатар аймгийн
1,2,3,4 дүгээр
сургуулийн үйл
ажиллагаатай
танилцах аялалд
13 багш

Дархан хотод
болсон “Англи
Хэлний заах аргын
чуулган”-д 5 багш
хамрагдсан.



6.Сургуулийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох

Итгэлтэй утас

Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй аян

Сургалт мэдээлэл

Орчин бүрдүүлэлт

Бага сургуулийн 1 давхарт "Итгэлтэй утас" ажилууллаа. Сурагчид хичээлийн дараа өөрийн эцэг эх, асран хамгаалагчидтай холбоо барихаар тогтмол ашиглаж байна.

"Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй" аяны үйл ажиллагааг сурталчилсан 2 өдрийн аяныг ангийн дарга нартай хамтран зохион байгуулсан. 2000 гаруй суралцагч, 500 гаруй эцэг эх, 100 гаруй багш ажилтнуудад мэдээлэл хүргэсэн.

"Хамтдаа шалгая, Эрсдэлээс ирээдүйгээ аваръя" сургалт мэдээллийг 2000 гаруй суралцагч, 500 гаруй эцэг эх, 100 гаруй багш ажилчдад хүргэж ажиллалаа.

Бага, ахлах сургуулийн шатны хэсэг, ариун цэврийн өрөөнд электрон тамхины хор уршиг, үе тэнгийнхний дээрэлхэлтийн талаар мэдээлэл байрлуулсан.



7. Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Байгууллагын Дотоод хяналт шалгалтын нэгж нь 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу сургуулийн гадна, дотор орчны үнэлгээг зохион байгууллаа. Орчны эрсдэл 65 оноо буюу дунд эрсдэлтэй дүгнэгдсэн бөгөөд цаашид анхаарах дараах эрсдэлийг бууруулан ажилласан.

Аймгийн цагдаагийн газарт албан хүсэлт хүргүүлэн сургуулийн хойд талын төв замд тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч, замын хашлага хийлгэж замын хөдөлгөөний эрсдэлээс урьдчилан сэргийллээ.

Сургуулийн хашааны эвдэрсэн, хугарсан хэсгийг багш, ажилчдын оролцоотой засаж аюулгүй орчин бүрдүүллээ.

Тэргэнцэртэй иргэн хэн нэгний тусламжгүйгээр өөрөө нэвтрэх боломжийг бүрдүүлж налуу шатыг стандартын дагуу хийсэн.

Бохирын 2 худгийн тагийг шинэчилсэн. Мөн ахлах сургуулийн цахилгааны монтажийг 100 хувь шинэчилж аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллалаа.



8. Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ

1 төгсөгч- 1 багш хөтөлбөр

Дунд, ахлах ангийн багш нар 12 дугаар ангийн сурагчдаас 1 сурагчийг сонгон хичээлийн жилийн турш тухайн сурагчийн хичээлийн оролцоо, ЭЕШ-ийн бэлтгэлд хяналт тавьж зөвлөгөө өгч ажиллаж байна. Үүний дүнд 2023 оны хичээлийн жилд ЭЕШ-ын үнэлгээгээр хичээл тус бүрээр амжилтаа ахиулсан сургуулиар шалгарсан.

Өглөөний уншлага

Бага ангийн сурагчид хичээл эхлэхээс 15-20 минутын хугацаанд сургамжит өгүүллэг, богино эхийг уншиж, ойлгосноо багш, эцэг эхтэйгээ хамтран ярилцаж хэвшил болоод байна. “Өглөөний угшлага” -ыг тогтмол зохион байгуулснаар сурагчдын ойлгон унших чадвар, үгийн баялаг нэмэгдэж олон талын мэдлэг мэдээлэлтэй болсон давуу талтай.

“Квадрат тэгшитгэл” 1000 бодлого


6-8-р ангийн сурагчдаар бие даалт хэлбэрээр улиралд 250, нийт 1000 бодлого бодуулж хичээлийн жилийн төгсгөлд үр дүнг “Мини олимпиад”, “Бодлогын дэвтрээр үзэсгэлэн”, “Математикч анги”, “Өндөр гүйцэтгэлтэй сурагч”-ийг шалгаруулж хэвшсэн үр дүнгээ өгсөн ажлын нэг.

Үндэсний өв соёлоо түгээгч- тээгчид

“Үндэсний өв соёлоо тээгч түгээгч” улсын уралдаанд “1 багш 1 анги” сонгон сурагчдын үндэсний бичгийн хичээлийн унших бичих, чадварыг массаар нь хөгжүүлдэг. Энэ хичээлийн жилд улсын уралдааны 10 дахь медалиа хүлээн авсан.

Өглөөний бодлого

Бага ангийн сурагчдаар хичээл эхлэхээс 15-20 минутын хугацаанд сонирхолтой IQ бодлого бодуулж цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж байна. Сар, улирлын эцэст хамгийн олон бодлого зөв бодож, цагийг үр бүтээлтэй өнгөрүүлсэн сурагчдыг урамшуулан сэтгэн бодох чадварыг дэмжиж байна.

A stylized illustration of a laptop with a black bezel and a light gray body. The screen is white and displays a congratulatory message in blue, uppercase Mongolian text. The laptop is shown from a slightly elevated perspective, casting a soft shadow on the white background.

АНХААРАН СОНССОН
ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА